





Сурацаггаа
МЭРГЭЖЛЭЭРЭЭ
Ажиллах
• Б О Л О М Ж •

МЭРГЭЖИЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Мэргэжил бол нэг сонгосон хойно насан туршдаа ашиглаж, хөгжүүлж, мөнгө олж болох тэр арга хэрэгсэл, ур чадварын хослол юм. Сургуулиа сонгохоос өмнө мэргэжлээ сонгох хэрэгтэй. Эхлээд хамгийн дуртай, хамгийн сайн хийж чаддаг зүйлсээ бодож сонгох хэрэгтэй, зарим тохиолдолд хамгийн өндөр цалин орлоготой, эсвэл хамгийн эрэлттэй, хамгийн нэр хүндтэй мэргэжлийг онцолж сонгож болно. Мөн гэр бүл, ойр дотны хүмүүсийн саналыг сонсох хэрэгтэй. Ямартай ч өөртөө хамгийн хамгийн санагдсан тэр мэргэжлийг сонгох нь зүйтэй.

Дараагаар нь энэхүү мэргэжлээр сургадаг сургуулиудаа жагсаагаад сургалтын давуу тал, суралцах орчин, багш нарын арга барил, оюутнуудын тухай мэдээлэл, байр байршил, төгсөгчид, элсэгчдэд тавих шаардлага гэх зэргээр нь харьцуулан өөрт хамгийн таалагдсан сургуулиа сонгох нь зүйтэй. Учир нь сургууль гэдэг бол ороод л гардаг тэр л газар биш, цөөнгүй жил хоёр дах гэр орон нь болж явах, насан туршийн найз нөхдөө олж авах, амьдрах, амжилттай явах арга замаа сурч авах амьдралын хамгийн чухал үе учир өөрт таатай, эргээд харамсахааргүй сонголт хийгээрэй.



ӨӨРТ БАЙГАА
**БОЛОМЖОО
НЭЭ!**

НЯГТЛАН БОДОГЧ, САНХҮҮЧ ГЭЖ ХЭН БЭ?

Нягтлан бодогч гэдэг нь бүхий л айл гэр, хувь хүн, албан байгууллагын мөнгөний орлого зарлага тооцоог хянаж, бүртгэж, төлөвлөж байдаг амин чухал мэргэжил юм. Хэрэв санхүүгийн тооцоолол нь алдаатай болвол тухайн ажил, бизнес нуран унаж, өрөнд орж, дампуурах аюултай.



ХЭРХЭН МЭРГЭЖЛИЙНХЭЭ ОРОЙД НЬ ГАРАХ ВЭ?

Нягтлан бодогч болохоор шийдсэн хүүхдүүд мэргэжил эзэмших сургуулиа сонгон суралцсанаар мэргэжлийн гараа эхэлдэг. Хүссэн сургуулиа амжилттай төгсөн бакалаврын зэргээ авсан төгсөгч хувийн болон төрийн байгууллагад нягтлан бодогчоор ажиллах боломжтой болдог. Ажил хийж эхэлсэнээр мэргэжилдээ эзэн болж илүү ихийг олж мэдэн дадлагаждаг ба энэ хугацаандаа боловсролоо ахиулан магистрын зэрэг хамгаалж болно. Хоёроос багагүй жил тасралтгүй мэргэжлээрээ ажиллан туршлага хуримтлуулсанаар Мэргэшсэн нягтлан бодогч цол авах эрхтэй болно. Энэхүү цолыг авсанаар байгууллагад өндөр албан тушаал эрхлэх, байгууллагын ерөнхий нягтлан бодогчоор ажиллах боломжтой болдог. Мэргэшсэн нягтлан бодогч болсоноор хэсэг хугацааны дараа Аудитор, Татварын мэргэшсэн зөвлөх болж болох ба ингэсэнээр нягтлан мэргэжлийн хамгийн өндөр нэр хүндтэй ажлуудыг хийх эрхтэй болно.



ИНСТИТУТ ГЭЖ ЮУ ВЭ?

Институт гэдэг нь сургалт явуулахаас гадна аливаа нэг мэргэжлээр дагнан судалгаа хийх, хөгжүүлэх, тухайн мэргэжлийн холбоотой шинийг санаачлах, шинэ санааг урамшуулан дэмжих мэргэжлийн цогц үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

PTI институт нь Идэр их сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн салбар сургууль бөгөөд нягтлан бодох бүртгэл, санхүүгийн мэргэжлийг шинжлэх ухаанчаар сургалт – судалгаа – дадлагын цогц шийдэл бүхий аргаар зааж сургах үйл ажиллагаа явуулж байна.

PTI хөтөлбөр нь Тодсанхүү Бизнесийн Сургууль, Монголын Үндэсний Тайлагнал Аудит, Ур чадвар боловсролын үнэлгээний төв, Татварын мэргэшсэн зөвлөгөө өгөх болон санхүүгийн бүх чиглэлийн консалтинг компани гэх мэт 10 гаруй санхүүгийн чиглэлийн байгууллагыг нэг дор нэгтгэн оюутан суралцагчид болон багш ажилчид, боловсон хүчээ байнгын хөгжүүлж, сургалт – судалгаа – дадлагын орчныг бодитоор бүрдүүлэн ажилладаг институтын хамгийн том хөтөлбөр юм.



PTI СОНГОХ ШАЛТГААН:



“

Суралцангаа дадлагажих нь

Чадварлаг мэргэжилтнийг бэлтгэхэд тухайн бодит орчинд сургах нь хамгийн үр дүнтэй байдаг.



“

Кареераа эрт эхлүүлдэг.

Энэ нь бусдаас түрүүлж алхахад тусалдаг. Өөрөөр хэлбэл бидний гол өрсөлдөгч бол цаг хугацаа юм.



“

Анхны цалингаа оюутан байхдаа авч эхлэх нь **бие даасан, гэр бүлдээ нэмэртэй** байх боломжийг олгоно.



“

Орлоготой оюутан өөрөө төлбөрөө төлдөг.



“

PTI институтэд суралцсанаар

танхимийн хичээлийг судалгааны багш нараар, практик хичээлийг мэргэшсэн зөвлөхүүдээр заалгадаг.



“

Суралцаж байх хугацаандаа мэргэжлээрээ ажиллаж цалинжих нь оюутнуудад мэргэжилдээ дуртай болох ирээдүйдээ итгэлтэй байхад нь тусалдаг.



“

Ажлын туршлагыг заавал төгсөж байж олж авах шаардлагагүй.



СУРАЛЦАНГАА ДАДЛАГАЖИХ ТУХАЙ

Оюутан байх хугацаандаа сургалтын хөтөлбөрийн дагуу 1-2 удаа богино хугацаагаар дадлага хийдэг ба энэ нь номноос үзсэн зүйлсээ бататгах боломжийг бүрэн олгодоггүй. Харин РТИ хөтөлбөр нь оюутнуудаа 2-р дамжаанаас эхлэн мэргэжлээрээ санхүүгийн байгууллагуудад ажиллах боломжийг олгох ба ингэснээр тухайн хичээлүүдээ бодит байдал дээр илүү таниж мэдэн өөрийн болгох боломжийг олгоно.

Түүнчлэн дадлагын ажил хийх явцдаа өөрийн хийсэн ажлаа үнэлүүлэн цалин авч, төгссөн хойноо ажлын туршлагатай үнэ цэнэтэй, чадварлаг мэргэжилтэн болох болно.

PTI ХӨТӨЛБӨРИЙГ ТӨГССӨНИЙ ДАРАА:

Манай төгсөгчид 3 хүртэл жил ажилласан ажлын туршлагатай, тухайн хугацаандаа

Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн, олон улсад магадлан итгэмжлэгдсэн бакалаврын зэрэгтэй төгсдөг. Мөн оюутнууд PTI хөтөлбөрт суралцаж төгсөөд дадлагажиж байсан байгууллагадаа үлдэн ажиллах, эсвэл санал болгосон бусад байгууллагуудад орж ажиллах боломжтой.

Цаашдаа мэргэжлээрээ ажиллаж буй төгсөгчид маань богино хугацаанд мэргэжлийн ур чадвараа ахиулан, бусад хөтөлбөрийн оюутнуудаас 5-10 жилийн өмнө мэргэжлийнхээ оройд хүрэх ховорхон боломжийг олж авна.





Улаанбаатар хот, Чингэлтэй
дүүрэг, 5-р хороо,
"М Плаза" Оффисын 6 давхарт
"PTI" Институт & "Тодсанхүү"
Бизнесийн сургууль



8960-1000, 9908-5009, 7015-1000



info@pti.mn



Даваа - Баасан гарагт
08:00 - 20:00 цаг



Сурацацгаа
МЭРГЭЖЛЭЭРЭЭ
Ажиллах
• Б О Л О М Ж •